

Захиргааны зөвлөлийн 2025 оны 04 сарын 02 өдрийн хурлаар батлав.

**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ИДЭР ИХ СУРГУУЛИЙН
СУРГУУЛЬ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ**



2025-2026 оны хичээлийн жил

Идэр Их сургууль нь 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхдээ БШУ-ны сайдын 2024 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам" болон энэхүү журмыг баримтална.

Нэг. Элсэлтийн комисс

1.1 Идэр Их сургуулийн элсэлтийн бүх асуудлыг элсэлтийн комисс хариуцна. Энэ комисс нь өдөр, орой, эчнээ, магистрын сургалтад сурахыг хүсэгчдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч хариу өгөх, элсэлтийн сурталчилгаа өрнүүлэх зэрэг өргөн эрх үүрэгтэй нэгж юм.

1.2 Элсэлтийн комисс нь холбогдох хууль, дүрэм болон энэхүү журмыг баримтлан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

Хоёр. Хэн орох боломжтой вэ?

2.1 Тус сургуульд элсэгч нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн байвал зохино. Үүнд:

2.1.1 Боловсролын яамнаас тогтоосон ЕШ-ын босго оноог давсан сурагч элсэх боломжтой. Өдрийн ангид элсэгчдийн хувьд үүнээс өөр нэмэлт шалгуур тавихгүй.

2.1.2 Орой ба эчнээ ангид элсэгч нь их дээд сургууль төгссөн байх шаардлагатай.

2.1.3 Магистрын сургалтад зөвхөн бакалаврын дээд боловсролтой мэргэжилтнүүдийг хамруулна.

2.1.4 Гадаадын элсэгч нар ерөнхий шалгалттай төстэй шалгалтыг өөрийн орондоо өгсөн байх мөн монгол, англи хэлний аль нэгээр ярьж, бичих тодорхой чадварыг илэрхийлсэн гэрчилгээтэй байх ёстой.

2.2 Тус сургуульд элсэгч нь тухайн элсэх мэргэжлийн хүрээнд зохих шалгалтуудыг өгсөн байна (Хүснэгт 1-ээс харна уу)



Гурав. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа

3.1 Идэр Их сургуулийн оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь зохион байгуулалтын хувьд элсэлтийн төв комисс ба орон нутаг дахь элсэлтийн багууд гэсэн бүтэцтэй байна.

3.2 Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь сурагч, эцэг эхчүүд, сонирхогч талуудад нээлттэй бөгөөд тэдэнд хүргэж буй мэдээлэл нь үнэн бодитой байна.

Дөрөв. Элсэгчдийн хүсэлтийг хүлээн авах

4.1 Элсэгчид нь тус сургуулийн элсэлтийн комисст дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Боловсролын гэрчилгээ, хувийн хэрэг
- Төгссөн сургуулийн диплом
- Өргөдлийн маягт
- ЕШ-ын оноо
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Авьяас, чадварын тухай тодорхойлолт
- 3x4 хэмжээтэй цээж зураг 3%

4.2 Элсэлтийн комисс хүсэлт хүлээн авсны дараа элсэгчдийн ЕШ-ын дүн, боловсролын гэрчилгээний голч дүнг харгалзан цуваагаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулалт хийж элсүүлнэ.

Тав. Хяналтын тоо (квотын тухай)

5.1 Сургалтын чанарын үүднээс 2025-2026 оны хичээлийн жилд Идэр Их сургуулийн өдрийн бакалаврын ангид элсэгчдийн тоог сургуулийн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

5.2 Зарим шаардлагатай мэргэжлээр ур чадварын шалгалт нэмэлтээр авч болно.

Зургаа. Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх

6.1 Идэр Их сургуулиас зохион байгуулсан уралдаан, тэмцээнд амжилттай оролцон урилга хүлээн авсан

6.2 Аймаг, хот, улсын олимпиадад шагналт байр эзэлсэн элсэгч

6.3 Урлаг, спортын онцгой авьяас чадвартай сурагч шууд элсэж болно.

6.4 Хөнгөлөлттэй нөхцөлөөр сурахыг хүсэгчид 8-р сарын 15-ны дотор холбогдох баримт бичгээ бүрдүүлэн элсэлтийн комисст хүлээлгэн өгнө.

Долоо. Санхүүгийн дэмжлэг тусламж

7.1 Оюутны хөгжлийн зээл

7.2 Багш мэргэжлийн хөтөлбөрүүдэд элсэж буй эрэгтэй элсэгчид болон мэдээллийн технологийн хөтөлбөрүүдэд элсэж буй эмэгтэй элсэгчдэд тэтгэлэгийг шатлал ахиулан олгож болно.

7.3 Идэр Их сургуулийн тэтгэлэгт шаардлага хангасан элсэгчийг ил тод, нээлттэй тэгш хамруулна.

Найм. Татгалзах нөхцөл

Элсэлтийн комисс нь дараах тохиолдолд татгалзсан хариу өгч болно.

8.1 Бүрдүүлсэн материал шаардлага хангаагүй

8.2 Тухайн мэргэжлээр элсэгчдийн хяналтын тоо дууссан

8.3 Орой, эчнээ, магистрт элсэгчдийн хувьд өмнөх боловсролын шаардагдах түвшин хүрэхгүй байгаа

8.4 Элсэгчийн хүсч байгаа санхүүгийн дэмжлэг тусламжинд хамруулах боломжгүй зэрэг болно.

Ес. Хэрхэн хандах вэ?

Элсэхийг хүсэгчид интернет, факс, утас, шуудан зэрэг бүхий л хэрэгслээр комисст хандаж болохоос гадна өөрсдөө биеэрээ ирж сургууль, мэргэжилтэй танилцах боломжтой байдаг. Сонирхсон хүмүүс манай сургуулийн өргөдлийн маягыг татан авч шуудангаар явуулах юмуу ОНЛАЙН хэлбэрээр (www.burtgel.ider.edu.mn), www.ider.edu.mn/register бүртгүүлж болно. Идэр Их сургуульд ингэж бүртгүүлэх нь үнэгүй байна.

ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠯᠲᠡᠢ
7248712

ИХ
/нь

АР ХОТ
ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠯᠲᠡᠢ

ИДЭР ИХ СУРГУУЛЬ

Элсүүлэх мэргэжлүүдийн нэрс

2025-2026 оны хичээлийн жил

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭЕШ-1	Босго оноо	ЭЕШ-2	Босго оноо
1	032101	Сэтгүүл зүй	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490
2	042101	Эрх зүй	Нийгэм судлал	490	Математик Англи хэл	490
3	092301	Нийгмийн ажил	Нийгэм судлал Англи хэл	490	Монгол хэл Математик	490
4	011201	Багш, сургуулийн өмнөх насны боловсрол	Монгол хэл Нийгэм судлал	440	Ур чадварын шалгалт	490
5	011301	Багш, бага боловсрол	Монгол хэл Математик	450	Ур чадварын шалгалт	490
6	011430	Багш, Монгол хэл, уран зохиолын боловсрол	Монгол хэл	490	Ур чадварын шалгалт	490
7	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490
8	041301	Бизнесийн удирдлага	Математик	490	Англи хэл Нийгэм судлал	490
9	041401	Маркетинг	Математик	490	Нийгэм судлал Англи хэл	490
10	041303	Менежмент	Математик	490	Англи хэл Нийгэм судлал	490
11	101501	Аялал жуулчлал	Математик Газар зүй	490	Нийгэм судлал Англи хэл	490
12	041101	Нягтлан бодох бүртгэл	Математик	490	Англи хэл Нийгэм судлал	490
13	061302	Программ хангамж	Математик Физик	490	Нийгэм судлал Англи хэл	450
14	061304	Мэдээллийн технологи	Математик Физик	490	Нийгэм судлал Англи хэл	450
15	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи	Математик Хими	490	Нийгэм судлал Англи хэл	450
16	072102	Хоол зүй, шим судлал	Математик Хими	490	Нийгэм судлал Англи хэл	450
17	061202	Кибер аюулгүй байдал	Математик Физик	490	Нийгэм судлал Англи хэл	450
18	061902	Хиймэл оюун ухаан	Математик Физик	490	Нийгэм судлал Англи хэл	450